

Хичээлд ажиглалт хийх

Та хичээлийн юуг ажигладаг вэ?

“Point”

Г. Норжмаа

МХСН-ийн гүйцэтгэх захирал

2015.01.21

Хичээл ажиглах “Point”:

- Таны хичээлээс юугаараа ялгаатай байна вэ?
- Хичээлийн зохион байгуулалт (эхлэл, өрнөл, төгсгөл хэсэг гэх мэт)
- Багшийг (зааварчилгаа өгч байгаа үг хэллэг, хараа, үйл хөдлөл)
- Сурагчийг (яриа, хоорондын харилцаа, дэвтэр хөтлөлт гэх мэт)
- Хичээлийн хэрэглэгдэхүүн (ашиглагдах байдал, ICT ашиглаж байгаа байдал)
- Ангийн орчин (ширээ тойрч эргэх, үзүүлэн, сургалтын тоног, төхөөрөмж)

Хичээл ажиглах “Point” (Эхлэл)

- Хичээлд хөтлөн орох сэтгэл зүйн бэлтгэл хийсэн эсэх
- Сонирхол төрүүлж, сэтгэл татах оролдлого хийсэн эсэх (зураг, видео үзүүлэх, сонирхолтой яриа ярьж сэдэлжүүлэх гэх мэт)
- Хичээлийн зорилгоо сурагчидтайгаа хуваалцсан эсэх
- Нийт сурагчдад хараа тавьж, суралцах үйлд бэлдэж чадаж байгаа эсэх

Хичээл ажиглах “Point” (Өрнөл)

- Асуултууд хичээлийн зорилготой холбогдож байгаа эсэх
- Төлөвлөсөн үйл ажиллагаа зорилгоо биелүүлэхэд ач холбогдолтой байгаа эсэх
- Хүүхэд өөрөө болон багаараа тунгаан бодох цаг гаргаж байгаа эсэх
- Түрүүлж яваа эсвэл хоцорч яваа хүүхэдтэй ажиллах бэлтгэл хангасан эсэх
- Ямар чадварыг нь хөгжүүлэхээр зорьж байна, түүнийг тооцож байгаа эсэх
- Хүүхдээр суралцах аргыг олж авах оролдлого хийлгэж байна уу?
- Мэдлэгийг өөрийн болгож авах оролдлого хийлгэж байна уу?
- Ширээ эргэж явахдаа олж мэдсэн хүүхдийн алдаа буюу бүдрэлтийг бусад хүүхдүүдтэй хуваалцаж байна уу?



Хичээл ажиглах “Point” (Дүгнэлт)

- Дүгнэлтийг хүүхдээр гаргуулж байгаа эсэх
- Гаргасан дүгнэлт тавьсан зорилготойгоо нийцэж байгаа эсэх
- Хичээлийн эцэст үнэлгээ хийгдсэн эсэх
- Бүх хүүхэд хичээлийг бүхэлд нь эргэн харж дүгнэж чадсан эсэх

Хичээл ажиглах “Point” /Хичээлийн хэрэгсэл, ажлын хуудас, самбар төлөвлөлт/

- Хүүхдэд ойлгомжтой байхыг зорьж байгаа эсэх
- Чухам яг энэ хэрэглэгдхүүнийг ашиглахгүй бол болохгүй шалтгаанаа тайлбарлаж чадах эсэх
- Буруу ойлголт авч магадгүй хэрэглэгдхүүн байгаа эсэх
- Энэ хичээлд ажлын хуудас шаардлагатай байсан эсэх
- Ажлын хуудас нь дэвтрийн ажиллагаатай холбоотой байхаар бэлдсэн эсэх
- Ажлын хуудсан дээр хүүхдийн сэтгэн бодох үйл бичигдэж үлдэхээр хийгдсэн эсэх
- Самбарт бичигдэж байгаа үсгийн хэмжээ хүүхдийн нас, хөгжилд тохирсон эсэх
- Самбарт бичигдсэн үгийн өнгө, шохойны сонголт тохиромжтой байгаа эсэх
- Самбарт хүүхдийн санаа бичигдэж үлдсэн эсэх
- Самбар төлөвлөлт хэр байна, нэгтгэн дүгнэх боломжтой хичээлийн явц харагдахаар үлдсэн байгаа эсэх

Хичээл ажиглах “Point” (бүхэлд нь)

- Зорилгодоо хүрч чадсан уу(Яагаад хүрсэн гэж үзэв)
- Тайлбар ойлгомжтой байсан уу?
- Асуулт зөв, тодорхой байсан уу? (Юу асууж байна, юу бодож, тунгаах нь зүйтэй байна)
- Асуулт тавьснаар хүүхдийн санаа бодолд эргэлзээ гарч байна уу (илүү өргөн хүрээнд, илүү гүнзгий бодсон гэдгийг заан тайлбарлаж чадах уу)
- Багшаас өгч байгаа даалгавар тодорхой байсан уу? (юуг, ямар түвшинд, ямар хугацаанд)
- Хүүхдээс гарч байгаа олон санааг цэгцэлж өгч чадаж байна уу
- Дүрэм, журам болон найз нөхдөө хүндэлж сурах хичээл зохион байгуулж байна уу?

Хичээл ажиглахад анхаарах зүйл

Багшийн зүгээс

- Хичээлийн аль хэсэг хамгийн амжилттай явагдсан бэ? Шалтгаан нь юу гэж бодож байна вэ?
- Эсрэгээр аль хэсэг амжилтгүй болсон бэ? Шалтгаан нь юу байв бодож үзсэн үү?
- Хичээлийн явцад хүүхдүүд ямар хэсгийг яг сайн алдаа мадаггүй ойлгож чадсан гэдгийг хэлж чадах уу?
- Хичээлийн явцад хүүхдүүд ямар хэсгийг үнэн сэтгэлээсээ ойлгож чадсан гэдгийг хэлж чадах уу?
- Хоцрогдолтой хүүхэдтэй ажиллах тодорхой төлөвлөсөн төлөвлөгөө байгаа юу? Жишээ хэлж чадах уу?
- Хичээл зорилгодоо хүрсэн, эс хүрсэн тухай тодорхой хувилж дүгнэж байна уу? Шалтгааныг нь хэлж чадах уу?

Баярлалаа